2026 оны 11 сарын 7-нд
хуралдсан
ИОН намын Төлөөлөгчдийн Танхимын
2026 оны 2-р хурлын
3-р тогтоолын 2-р хавсралт

ИОН НАМААС ТӨРИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИХЭЭ ИЛЭРХИЙЛСЭН ГИШҮҮДИЙН ТАНДАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журам нь ИОН намын дүрмийн 20.3-д заасны дагуу ИОН намын гишүүд төрийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийг намын Тандалт үнэлгээний ажлын хэсгээс (ТҮАХ) мэдээлэл цуглуулах, гишүүдийг үнэлэх, эрэмбэлэх, эрэмбийг нэр дэвшүүлэх дотоод сонгуулийн саналын хуудсанд тусгах үйл ажиллагаа, түүнтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Тандалт үнэлгээний ажлын хэсгийг ИОН намын дүрмийн 18.5.3, 15.4.8-д заасны дагуу Намын даргын тушаалаар байгуулна.

1.3 Энэ журмын 1.2-т заасан тушаал гарсан даруйд Тандалт үнэлгээний ажлын хэсгийн дарга тус ажлын хэсгийн анхны хурлыг товлон зарлана. Тандалт үнэлгээний ажлын хэсгийн анхны хурлаар намын дүрмийн 20.30.1-д засан намын гишүүний тандалт үнэлгээнд зориулсан хувийн тайланг хүлээж авах хугацаа, хүлээн авах хаягийг тогтооно. Хурлын шийдвэрийг намын дүрмийн 27.3-т заасан хэлбэрээр нийтийн зараар түгээнэ.

1.4 Тандалт үнэлгээний ажлын хэсгийг д отоод сонгууль болон Төрийн сонгуульд нам нэр дэвшүүлэх тухай хуульд заасан эхний хугацаанаас дор хаяж 30 хоногийн өмнө байгуулах ба ТҮАХ-ийн гишүүдийн тоо нь тандалт үнэлгээнд хамрагдах боломжтой хуримтлал бүрдүүлэгч гишүүдийн тооноос хамааран өөр өөр байж болно.

1.5 Тандалт, үнэлгээний ажлын хэсэг тухайн шатны сонгуульд нэр дэвших боломжтой тандалт үнэлгээнд хамрагдсан нийт хуримтлал үүсгэгч гишүүдийг авсан онооны дарааллаас ихээс бага руу эрэмбэлэх ба, Дотоод сонгуулийн ажлын хэсгийн зарын дагуу тухайн шатны сонгуульд нэр дэвшихээ илэрхийлж өргөдлөө гаргасан нэр дэвшигчдийн эрэмбэ, авсан оноог Дотоод сонгуулийн ажлын хэсэгт нэр дэвшигчдийг тодруулах дотоод сонгуулийн саналын хуудсыг бэлтгэхээс өмнө хүлээлгэн өгнө.

1.6 Хэрэв Дотоод сонгуулийн ажлын хэсгээс зарласан товын дагуу нэр дэвшихийг хүссэн материалаа ирүүлээгүй, нэр дэвшилт дутуу байснаас үүдэн төрийн сонгуульд намаас нэр дэвших сул орон тоо гарсан бол уг орон тоонд нэр дэвшүүлэх эрх бүхий намын хурлын үеэр Тандалт Үнэлгээний ажлын хэсгийн судалгаанд хамрагдаж оноо цуглуулсан хуримтлал бүрдүүлэгч гишүүд нэрээ дэвшүүлж өрсөлдөх эрхтэй.

Хоёр. Нэр дэвшигчийг тандах үндсэн үзүүлэлтүүд

2.1. ИОН намын дүрмийн дагуу гишүүн дараах байдлаар өөрийгөө илэрхийлсэн бол тухайн гишүүний талаар тандалт үнэлгээг зохион байгуулна. Үүнд:

a. Улс төрийн хуримтлалын дансыг өөртөө нээж, тус хуримтлалын 1%-аас бага хэмжээний хуримтлал бүрдүүлэгч гишүүний татварыг намын дансанд төлсөн;

b. Төрийн ээлжит сонгуулийн хооронд хамгийн багадаа нэг удаа намын хандивлагчаар бүртгэгдсэн;

2.2. Энэ журмын 2.1-д заасан гишүүдийн дунд тухайн шатны сонгуульд нэр дэвших боломжтой бөгөөд хүсэлтээ илэрхийлсэн гишүүдийг хамруулан дараах 5 үзүүлэлтээр тандалт үнэлгээг явуулна. Үүнд:

2.2.1. Дотоод үйл ажиллагааны үзүүлэлт: ИОН намаас дотоод болон төрийн сонгуульд нэр дэвшигч нь намын дотоод үйл ажиллагаа, уулзалт, хурал, татвар төлөлтийг эрчимжүүлэх, намаас нэр дэвшигчийг сонгуульд дэмжиж ажиллах зэрэг намын дотоод үйл ажиллагааг зохион байгуулах, идэвхижүүлэх, намын дүрмийг хэрэгжүүлэх, дотоод үйл ажиллагааны соёлыг төлөвшүүлэх зорилго бүхий ямарваа ажлын хэсэгт орж ажилласан эсэх;

2.2.2. Нээлттэй үйл ажиллагааны үзүүлэлт: ИОН намаас дотоод болон төрийн сонгуульд нэр дэвшигч нь намаас зохион байгуулсан нээлттэй үйл ажиллагаа, сургалтуудад модератор, панелист, судлаач, контент бэлтгэгч, олон нийтийг татан оролцуулах зохион байгуулагчаар ажилласан эсэх;

2.2.3. Нийгмийн сүлжээн дэх үзүүлэлт: ИОН намаас дотоод болон төрийн сонгуульд нэр дэвшигчийн сошиал орчин дахь танигдалт ба идэвхи;

2.2.4. Бодлогод нөлөөлөх үзүүлэлт: ИОН намаас боловсруулах хуулийн төсөл, бодлогын шийдлийн төслийг ганцаараа болон бусадтай хамтарч боловсруулсан, шийдэлд санал оруулсан, шийдлийн төслийг туршиж үнэлгээ шүүмж өгсөн, шийдлийн төслийн талаар олон нийтийн санаа бодлыг цуглуулж намын гишүүдэд танилцуулсан эсэх.

2.2.5. Оролцооны соёл төлөвшлийн үзүүлэлт: Мэдлэг, мэдээлэл, тайлан, мэдээг намын гишүүдтэйгээ болон олон нийттэй хуваалцах үйл ажиллагааны нээлттэй, идэвхитэй байдал, иргэдийн оролцооны аргыг өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байдал;

2.3 Тандалт үнэлгээний ажлын хэсэг нь энэхүү журмын журмын 3-р зүйлд заасан үнэлгээ хийх аргачлалаар намын гишүүний авсан нийт оноог хүснэгтээр гаргаж, Дотоод сонгууль зохион байгуулах түр ажлын хэсэгт төрийн сонгуульд нэр дэвших сонирхлоо илэрхийлэх хугацаа хаагдахаас 3 хоногийн өмнө илгээнэ.

2.4 Энэхүү журмын 2.1-д заасан хүснэгтэнд Тандалт үнэлгээний ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулахаас гадна, тухайн үнэлгээний дүнг гаргасан хурлын тэмдэглэл, бусад нотлох баримтыг хавсаргасан байна.

Гурав. Үнэлгээ хийх аргачлал

3.1 Гишүүн нь дотоод болон төрийн сонгуульд нэр дэвшихдээ дараах 5 үзүүлэлтээр заавал үнэлгээ хийлгэсэн байна.

3.2 Үндсэн үзүүлэлт буюу энэхүү журмын 2.2.1-2.2.5-д заасан таван үзүүлэлтийг нэгтгэн нэр дэвшигчид 1-100 хүртэл оноог өгнө.

3.3 Үндсэн үзүүлэлт нэг бүрийн нийт оноонд эзлэх хувь хэмжээ дараах байдлаар байна.

I.	Дотоод үйл ажиллагааны үзүүлэлт	25%
II.	Нээлттэй үйл ажиллагааны үзүүлэлт	20%
III.	Нийгмийн сүлжээн дэх үзүүлэлт	35%
IV.	Бодлогод нөлөөлөх үзүүлэлт	10%
V.	Оролцооны соёл төлөвшлийн үзүүлэлт	10%

3.4. Энэхүү журмын 3.3-т заасан үндсэн 5 үзүүлэлтийн дээд онооны болзлыг дор дурдсан оролцоог оруулсан намын гишүүн хангана. Үүнд:

3.4.1 ИОН намаас дотоод болон төрийн сонгуульд нэр дэвшигч нь намын ажлын хэсэг, хурал, татвар төлөлтийг эрчимжүүлэх аян зэрэг намын дотоод үйл ажиллагаанд сүүлийн 24 сард 10-с доошгүй удаа оролцсон;

3.4.2 ИОН намаас дотоод болон төрийн сонгуульд нэр дэвшигч нь намаас зохион байгуулж буй сургалтуудад модератор, панелистаар сүүлийн 24 сард 3-аас доошгүй удаа оролцсон;

3.4.3 ИОН намаас дотоод болон төрийн сонгуульд нэр дэвшигч нь Сошиал орчинд өөрийн болон намын үйл ажиллагааг дэмжих, болон өөрийн танигдалтыг нэмэгдүүлэхээр ажилласан байдал нь сүүлийн 12 сарын турш тасралтгүй бөгөөд ихэнхдээ өсөлттэй байсан;

3.4.4 ИОН намаас дотоод болон төрийн сонгуульд нэр дэвшигч нь намаас боловсруулах бодлогын шийдлийг байнга хайж, судалж, хэлэлцэж ажилласан ба тодорхой нэг шийдлийн талаар энэ журмын 2.2.4-т заасан ажлын аль нэгийг чадамгай гүйцэтгэсэн;

3.4.5 ИОН намаас дотоод болон төрийн сонгуульд нэр дэвшигч нь сүүлийн 24 сард намын гишүүдтэйгээ мэдээ мэдээлэл хуваалцах, туршлага солилцох, тайлангаа олон нийтэд танилцуулах зэргээр иргэдийн оролцооны соёлыг нэвтрүүлэх, хэвшүүлэх үйл ажиллагааг дор хаяж 24 удаа нээлттэй хэрэгжүүлсэн байх;

3.5 Үзүүлэлт тус бүрээр оноо бодохдоо дараах тооцооллыг ашиглана.

3.5.1 Журмын 3.4.1, 3.4.2, 3.4.4 ба 3.4.5-д заасан дээд босго тоог 100% гэж тооцох ба түүнээс дээш давсан тоог харгалзан үзэхгүй.

Жишээ нь: Хэрэв оролцсон байх босго тоо 3 бол түүнийг 100% гэж үзэх ба 2 удаа оролцсон бол 100-г босго тоонд хуваан тухайн тоонд харгалзах хувийг гаргаж ирнэ.

100 : 3 X 2 = 66.6%

Энэхүү хувийг тухайн үзүүлэлтийн нийт оноонд эзлэх хувиар тооцон гаргана.

Жишээ нь: Нээлттэй үйл ажиллагааны үзүүлэлт буюу сургалт, уулзалтанд оролцох оролцооны хувь 20% байгаа тохиолдолд

(66.6% X 20%): 100 = 13.2% гэсэн тоог гаргаж ирнэ.

3.5.2 Соошл дээрхи танигдалт болон намын дотоод үйл ажиллагаанд оролцсон идэвхийг үнэлэхдээ доорхи аргачлалыг ашиглана.

- Дагагчийн тоо: хэмжүүр нь постны лайкны дундаж дагагч нарынх нь хэдэн хувь нь лайк дарж дагадаг... жишээ нь 500 дагагчтай түүнээс 50 буюу 10% нь лайк байнга дарж дэмждэг бол 100 хувь, 10% -иас доош бол түүнд ноогдох хувийг оноож өгөх.
- Оруулсан постын тоо: улс төртэй холбоотой постыг сүүлийн 12 сарын турш оруулсан бол 100 хувь ба нэг сард ноогдох хувийг 100-г 12-т хуваан гаргаж тооцно.
- Пост рийл лайв стори (post, reels, story) тодотгож өгөх гээд шэйр хийсэн тоо: сараасаа хамаарахгүй дор хаяж 20 пост шэйр хийсэн бол 100 хувь гэж д үнэлэх
- Нам болоод улс төртэй холбоотой рийлс (reels) 5-10 удаа хийсэн бол 100 хувь
- Нам, улс төртэй хамааралтай зураг доод тал нь 15 удаа оруулсан бол 100 хувь

3.5.3 Соошл онооны дүнг нэгтгэн гаргахдаа 3.5.1-д заасан аргачлалыг ашиглана.

Дөрөв. Мэдээллийн хүрээ.

4.1. Тандалт Үнэлгээний Ажлын хэсгийнхэн намын гишүүний тандалт үнэлгээнд зориулсан хувийн тайлангийн мэдээллийг хөндлөнгийн баримтаас нягтлан шалгахдаа дараах өгөгдлүүдийн хүрээнд ажиллана. Үүнд:

4.1.1. Соошл хаяг (Facebook, Twitter, Instagram, Tik Tok, Youtube болон бусад идэвхтэй хэрэглэсэн гэж намын гишүүний тайланд тусгасан сошл хаяг)

4.1.2. Намын албан ёсны пэйж болон орон нутгийн салбарын пейж түүний мэдээллүүд

4.1.3. Хурал, уулзалтуудын баримт материал;

4.1.4. Маргаан таслах комиссын тогтоол;

4.1.5. Өрсөлдөгч гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд намын дүрмийн 20.3.3-т заасан нэмэлт санал асуулгын дүн

4.2. Тандалт үнэлгээний ажлын хэсэгт дараах албан тушаалтан дараах мэдээллийг гаргаж өгнө. Үүнд:

4.2.1. Намын санхүүч тухайн нэр дэвшигчийн хуримтлалын данс үүсгэсэн огноо ба хуримтлалын дансанд орлого хийсэн давтамж, он сарууд;
4.2.2. Намын санхүүч тухайн нэр дэвшигчийн хандиваар бүртгэгдсэн биет болон биет бус хандивын мэдээлэл;
4.2.3. Намын ерөнхий менежер, эсхүл намын нарийн бичгийн дарга намын ажлын хэсэг байгуулагдсан тухай намын дарга, ерөнхий менежерийн тушаал, намын хурлын материалууд, тогтоол болон тэмдэглэл гэх мэт ажлын хэсэг болон намын үйл ажиллагаанд оролцсон эсэхийг нотлох баримтуудыг тус тус гаргаж өгнө.
4.2.4. Намын салбар, танхимын дарга, ажилтан тухайн салбар, танхимын хурлын тогтоол, тэмдэглэл, тухайн салбар, танхимын хэмжээнд зохиогдсон үйл ажиллагааны хөтөлбөр, ажлын хэсгийн үйл ажиллагааны баримт.

Тав. Нэр дэвшигчдийн эрэмбийг хүргүүлэх дэс дараалал

5.1. Тандалт үнэлгээний ажлын хэсэг Төрийн сонгуульд нэр дэвшихээр үнэлгээ хийлгэсэн бүх нэр дэвшигчдийг авсан оноог хамгийн ихээс хамгийн бага хүртэл дараалуулан эрэмбэлж дараах дэс дарааллын дагуу дараах этгээдэд хүргүүлнэ.

5.1.1. Дотоод сонгуулийн ажлын хэсэгт нэр дэвшилтэд гишүүн саналаа илэрхийлэх хугацаа дуусахаас 3 хоногийн өмнө хүргүүлэх.
5.1.2. Тандалт үнэлгээнд хамрагдсан гишүүдэд нэгэн зэрэг хүрэх захидал харилцааны арга хэрэгслээр энэ журмын 6.1 -д заасан хугацаанд хүргүүлэх.

5.2. Тандалт үнэлгээний ажлын хэсгийн гишүүд Дотоод сонгуулийн ажлын хэсэгтэй энэ журмын Зургаадугаар зүйлд заасан гишүүний эрхийг хангуулахад хамтран ажиллах бөгөөд энэ журмын 7-р зүйлд заасан саналын хуудаст гарын үсэг зурна.

Зургаа. Намын гишүүнд эрэмбийн мэдээллийг хүргүүлэх , намын гишүүн өөрт давуу нэр дэвшилтийн хувилбарыг сонгох, жендерийн тэгш байдлыг хангах

6.1. Тандалт Үнэлгээний Ажлын хэсэг нь Дотоод сонгуулийн ажлын хэсгийн санал авах ажиллагаа дуусахаас 3 хоногийн өмнө тухайн шатны сонгуульд нэр дэвших боломжтой, тандалт үнэлгээ хийлгэн эрэмбээ тогтоолгож буй гишүүдэд бүгдэд нь хүртээмжтэй захидал харилцааны хэлбэрээр нэгэн зэрэг мэдээлэл өгч тухайн гишүүний нэр дэвшилтэд давуу талтай хувилбараа сонгон оролцох эрхийг хангана.

6.2. Намын гишүүн УИХ, Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын сонгуульд тойргоос нэр дэвших, эсхүл намын жагсаалтад орох гэсэн хоёр хувилбарын аль нэгийг сонгох ба, сонголт хийсэн шийдвэрийг ТҮАХ-ээс тогтоосон эрэмбийн дагуу Дотоод сонгуулийн ажлын хэсэг асуулт хариултын аргаар цуглуулан авч, тэмдэглэл хөтөлнө.
6.2.1. Хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигч хамгийн түрүүнд сонголт хийх эрхтэй. Хамгийн өндөр оноотой гишүүний нэрийг холбогдох хувилбарын дотоод сонгуулийн саналын хуудсанд хамгийн эхэнд жагсаана.
6.2.2. Дотоод сонгуулийн ажлын хэсэг хамгийн өндөр оноотой гишүүний саналыг хүлээж авснаас хойш ТҮАХ-ээс ирүүлсэн эрэмбийн дагуу дараагийн гишүүнээс асууж сонголт хийлгэнэ. Намын гишүүн шийдвэрээ гаргахад чухал ач холбогдолтой гэж үзсэн өмнөх гишүүдийн сонголтын тухай мэдээлэл, жендерийн харьцаа, сул орон тоо зэрэг мэдээллийг Дотоод сонгуулийн ажлын хэсгээс авах эрхтэй. .
6.2.3. Намын жагсаалтад орох хүсэлтээ илэрхийлсэн нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа, жагсаалт дахь хүйсийн дараалал нь сонгуулийн тухай хууль тогтгоомжид заасан жендерийн тухай заалтаас зөрсөн тохиолдолд, байдлаар Дотоод сонгуулийн ажлын хэсэг дотоод сонгуулийн саналын хуудсыг хууль нийцүүлэн бэлтгэх үүрэгтэй ба зөвхөн энэ зорилгоор ТҮАХ-ээс гаргасан эрэмбээс зөрсөн дараалал саналын хуудаст орж болно.
6.2.4. Энэ журмын 6.2.3-тай холбогдуулан гишүүдэд тойрог, жагсаалтын талаар дахин сонголт хийх боломж үүсвэл уг ажлыг зохион байгуулахдаа Дотоод сонгуулийн ажлын хэсэг өндөр оноотой гишүүнд түрүүлж хандах үүрэгтэй.

Долоо. Саналын хуудсыг хуралд оруулах.

7.1. Тандалт үнэлгээний ажлын хэсгийн энэ журмын дагуу бэлтгэсэн эрэмбийг баримталж, намын гишүүдийн нэр дэвших санал, Монгол улсын хуулийн дагуу бэлтгэсэн саналын хуудсыг бичгээр бэлтгэн Дотоод сонгуулийн ажлын хэсэг, Тандалт үнэлгээний ажлын хэсгийн гишүүдийн гарын үсэгтэйгээр холбогдох шатны хурлыг удирдах Төлөөлөгчдийн танхимын дарга, танхимын даргад хаяглаж хүргүүлнэ.
7.2. Дотоод сонгуулийн ажлын хэсгийн оруулсан саналын хуудас дэх нэрийн жагсаалт, жагсаалтад орсон эрэмбэ дарааллыг хуралд оруулахдаа хэн ч өөрчлөх эрхгүй.
7.3. Саналын хуудсыг хүлээн авсан Төлөөлөгчдийн танхимын дарга, холбогдох танхимын дарга нь саналын хуудсыг цахим санал хураалтын системд байршуулах томъёоллын хамт намын ажлын албанд хүлээлгэн өгнө.
7.4. Саналын хуудсыг намын цахим системд оруулахдаа уг жагсаалтын эрэмбэ дэх дэс дугаарыг өөрчлөх гүйгээр өрсөлдөөнгүй тойрог, жагсаалт дээр тусад нь багцлан нэг дор санал хураалгаж болно. Өрсөлдөөнтэй суудалд саналын хуудсыг тусад нь бэлтгэн оруулж санал хураалгана.

Найм. Журам хүчин төгөлдөр болох

8.1. Энэхүү журам нь 2026 оны 11 сарын 9-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.